



# СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

# МЭДЭЭ

№27 /241/

2022.02.09

Цаг үе, үйл явдал

## ЦЭРГИЙН ШТАБЫН ОФИЦЕР, АХЛАГЧ НАРААС СОРИЛ АВЛАА



Батлан хамгаалахын сайдын 2021 оны А/107 дугаар тушаалын дагуу цэргийн жинхэнэ албаны офицер, ахлагчийн түвшин тогтоох үзлэгт хүндэтгэн үзэх шалтгаанаар хамрагдаагүй болон хугацаатай үүрэг авсан офицер, ахлагч нарт тусгай

төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Энэхүү ажлын хүрээнд 2022 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас дээрх офицер,

ахлагч нараас биеийн жингийн зохистой харьцаа, биеийн тамирын бэлтгэлжилтийн нормативын сорилыг урьдчилсан байдлаар авч дүгнэв.

Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штаб

## АХМАДУУДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Билгийн тооллын XVII жарны "Буян үйлдэгч" хэмээх усан Бар жилийн Сар шинийн босгон дээр нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас 1 дүгээр сарын 25-наас энэ сарын 1-ний өдрүүдэд Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчинд олон жил үр бүтээлтэй ажиллаж нийслэл, дүүргийн Цэргийн штабаас тэтгэвэр, чөлөөнд гарсан ахмадууддаа Сар шинийн мэндчилгээ дэвшүүлэн, гарын бэлэг гардуулж хүндэтгэл үзүүлээ.



## ЦЭРГИЙН ЧУУЛГЫНХАН "ХАВРЫН БАЯР" ОЛОН УЛСЫН УРЛАГИЙН НААДАМД ОРОЛЦОХООР БЭЛТГЭЛ АЖЛАА ХАНГАЖ БАЙНА



Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсад зохион байгуулагддаг "Хаврын баяр" олон улсын урлагийн наадам энэ жил цахим хэлбэрээр ирэх 4 дүгээр сарын 10-20-ны өдрүүдэд зохион байгуулагдахаар товлогдсон бөгөөд ЦДБЭЧ-ын уран бүтээлчид эх орноо төлөөлөн оролцохоор бэлтгэл ажлаа хангаж байна.

Энэ жилийн "Хаврын баяр" олон улсын урлагийн наадамд

ЦДБЭЧ-ын уран бүтээлчид нэгдсэн бүрэлдэхүүнээрээ оролцож байгаа бөгөөд найрал дууны, үндэсний бүтээлийн болон бүжгийн шилдэг бүтээлүүдээрээ өрсөлдөж байгаа юм.

Тус чуулгын хамт олон 2018 онд зохион байгуулагдсан "Хаврын баяр" олон улсын урлагийн наадамд найрал дуучдын бүрэлдэхүүнтэйгээр оролцож Гран при шагнал, 6 алт, 2 мөнгөн цомын шагналыг хүртсэн юм.



Түүхэнд энэ өдөр

1947 он

Сайднарын зөвлөлийн тогтоолоор Барилгын 26 дугаар батальоныг барилга конторын ангийн хамт байгуулж, Д.Сүхбаатарын нэрэмжит Офицерын сургуулийг барилгуудыг / Богд хан уулын Зайсангийн аманд/ бариулах шийдвэр гарчээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-10	-30

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
34	24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,586.00	2,858.0
EUR	3,255.0	3,270.0
CNY	448.50	450.00
RUB	38.30	39.00
JPY	24.72	24.90
KRW	2.41	2.42

ЗУРХАЙ

2022.02.09 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 8/

ХАВРЫН ТЭРГҮҮН ХАР БАР САРЫН НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН МОГОЙ ӨДӨР

Үс засуулбал:

Нас уртасна

Наран ургах, шингэх:

08.09-18.04

Барилдлага:

Үхэх

Шүтэн барилдлага:

Авахуй

Суудал: Уул

ДОРНЫН ЗУРХАЙ:

Энэ өдөр үхэр, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, сан тавиулах, угаал үйлдэх, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, буг дарах, газрын ам бооход сайн.

Ургаа мод таслах, газрын ам нээх, сэтгэлд сэвтэй газар очих, байшингийн суурь тавихад муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой.

Хол газар яваар одогсод баруун хойш мөрөө гаргавал зохистой.

Үс шинээр үргээлгэх буюу засуулбал нас уртадна.

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН

2,269,936 /69.8%|

ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН

2,170,893 /66.7%|

ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН

1,009,379 31,0%

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН  
8046 +112

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ  
80

ЭДГЭРСЭН  
7849

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 398,173,224

Эдгэрсэн

Нийт: 317,743,575

Нас барсан

Нийт: 5,768,936



Монгол цэрэг энхийн үйлсэд

# ЗОРИЛТО НЭТЛЭЙ БҮСТҮЙЧҮД

Монгол Улсын Зэвсэгт хүчин энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойн хүрээнд Монгол Улсын Зэвсэгт хүчнээс Өмнөд Судан Улсад үүрэг

гүйцэтгэж байгаа XI ээлжийн мотобуудлагын батальоны эмэгтэй цэргийн алба хаагчдын төлөөлөлтэй хийсэн ярилцлагыг толилуулж байна.



**Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Урилгыг маань хүлээн авсан та хоёрт маш их баярлалаа. Ингээд уншигчдад өөрийгөө танилцуулна уу?**

-Намайг Ж.Цэрэнлхам гэдэг. Би Зэвсэгт хүчний 013 дугаар ангид станцын дарга жолоочоор 2008 оноос нийт 15 жил ажиллаж байна. Миний хувьд 2 хүүхдийн хамт амьдардаг. Нөхөр маань хэдэн жилийн өмнө зуурдаар бурхан болсон.

Хүүхдүүд маань их сургуулиа төгсөөд цэргийн хүмүүс болж, Хилийн цэрэгт алба хаадаг.

-Намайг Ц.Анхцэцэг гэдэг. Нөхөр, 3 хүүхдийн хамт амьдардаг. Нөхөр маань бас цэргийн хүн Зэвсэгт хүчний 150 дугаар ангид алба хаадаг. Үндсэн ажил мэргэжлийнхээ дагуу морзоор хичээллэдэг бүр хобби болгочихсон, спортын мастер цолтой. Дэлхийн болон улсын аваргын

Та хоёрыг багш

**шавийн холбоотой төдийгүй, оюуны спортоор хичээллэж багагүй амжилт үзүүлсэн гэж дуулсан. Энэ түүхээсээ хуваалцна уу?**

-Ж.Цэрэнлхам: -Энэ их сонирхолтой түүх л дээ. Миний хувьд олон жилийн өмнөөс радио спортын чимээний төрлөөр хичээллэдэг байлаа. Үндсэн ажил мэргэжлийнхээ дагуу морзоор хичээллэдэг бүр хобби болгочихсон, спортын мастер цолтой. Дэлхийн болон улсын аваргын

тэмцээнд цөөнгүй оролцож, чамлахааргүй амжилт олсон. Монгол Улсдаа энэ төрлөөр дээд амжилтыг тогтоож чадсан. Анхцэцэг маань Зэвсэгт хүчинтэй ажил, амьдралаа холбосноор радио спортыг сонирхох болж л дээ. Тэгээд л над дээр ирж байлаа. Манай хүн телеграфт илүү сонирхолтой. Ер нь сонирхол нэгтэй хүмүүс цаанаасаа л учрах хувьтай байдаг юм болов уу гэж бодогддог. Эхлээд компьютер дээр морз хийж байгаа бэлтгэлийг

дээд амжилтыг тогтоож чадсан. Анхцэцэг маань Зэвсэгт хүчинтэй ажил, амьдралаа холбосноор радио спортыг сонирхох болж л дээ. Тэгээд л над дээр ирж байлаа. Манай хүн телеграфт илүү сонирхолтой. Ер нь сонирхол нэгтэй хүмүүс цаанаасаа л учрах хувьтай байдаг юм болов уу гэж бодогддог. Эхлээд компьютер дээр морз хийж байгаа бэлтгэлийг

маань харчхаад "Та хүүхдийн тоглоом тоглоод байгаа юм уу" гэж билээ. Одоо Анхцэцэг маань бас спортын мастер цолтой. Шавиараа бахархаж байна.

-Ц.Анхцэцэг: -Би багш дасгалжуулагч мэргэжлээр биеийн тамирын сургууль төгссөн, гэр бүлийнхэн маань намайг мэргэжлээрээ ажиллахыг зөвлөдөг байлаа. Ээж маань өөрөө цэргийн хүн байсан учраас надад "Эмэгтэй хүнд цэргийн мэргэжил хэцүү, багшаараа ажиллаж болохгүй юм уу миний охин" гэж хэлж байсан. Гэсэн хэдий ч би өөрийнхөө сонирхол, хүсэл мөрөөдлийг дагаж телеграфтаар хичээллэсэн. Тухайн үед Зэвсэгт хүчний 124 дүгээр ангид курс хичээллэж, төгсөгчдөө ахлагч болгож авна гэж сонсоод очиж бүртгүүлэн суралцаж төгсөөд ахлагч болж байсан. Энэ мөч хэзээ ч мартагдахааргүй миний амьдралын хамгийн зөв шийдвэр байсан.

**Та хоёроор бахархаж байна. Тууштай байж мөрөөдлөө биелүүлнэ гэдэг сайхан чанар шүү дээ. Цэрэнлхам таны хувьд өмнө нь гурван удаа энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн чамгүй туршлагатай энхийг сахиулагч. Харин Анхцэцэг анх удаа хилийн чанадад үүрэг гүйцэтгэж байна. Сэтгэгдлээсээ хуваалцахгүй юу?**

-Ц.Анхцэцэг: -Би энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаадаа баяртай байна. Тэр тусмаа багштайгаа бадди болоод явж байгаа маань бүр ч талархалтай. Биднийг хувь тавилангаар учирсан хүмүүс гэхэд болно анхны ажлын гараа, анхны ажиллагаа гээд бүх зүйлтэй холбоотой тийм л сайхан хүн дээ багш маань.

-Ж.Цэрэнлхам: -Тийм шүү, баярлалаа. Би ч бас шавиасаа их зүйл суралцдаг. Ер нь төгс хүн гэж байдаггүй, үргэлж бие биеэсээ суралцаар л явдаг шүү дээ. Тиймээс хүн бүр хажуудаа байгаа хэн нэгнээс суралцах

хэрэгтэй гэж би боддог. Бид хоёр зорилго нэгтэй /инээв/, морзын дэлхийн аваргад оролцохоор бэлтгэлээ хангаж байгаа. Ажлынхаа амрах цаг заваар өөрийгөө хөгжүүлж бэлтгэлээ хийдэг хэчнээн ядарсан ч бид хоёр инээдээр бялхаж байдаг.

**Та хоёрыг мотобуудлагын батальоны "оёдлын босс" гэж ярьдаг энэ үнэн үү?**

-Ж.Цэрэнлхам: -Бид хоёрыг хүмүүс оёдлын босс гэж дуудах юм билээ. Гэхдээ энэ нь гоё хоч. Бид хоёрын хобби хүртэл адилхан. Яг л адилхан санааг олоод бодчихсон байдаг, түүнээсээ ч их урам зориг авч эрч хүчээ сэлбэж байдаг шүү. Нийт 100 гаруй цэргийн алба хаагчийн хувцас оёсон байна.

**Та хоёр бие биеэ нэг үгээр илэрхийлбэл?**

-Ц.Анхцэцэг: -Багш маань урам зориг, эрч хүч. Ж.Цэрэнлхам: -Шавь маань миний баруун гар гэж боддог.

**Эмэгтэй цэргийн алба хаагчдаа хандан урам зориг авах зөвлөгөө өгөөч?**

-Ж.Цэрэнлхам: -Уе үеийн батальонууд онцлогтой байдаг. Манай батальоны эмэгтэй цэргийн алба хаагчдын дийлэнх нь шинэ үеийн шижигнэсэн охид байна. Тиймдээ ч бүсгүйчүүд бид албандаа шамдан эх орныхоо нэрийг дурсгаж бид бүхнийг зөв сонгож явуулсан гэдгийг батлах болно.

Сонирхуулахад 2021 оны байдлаар Монгол Улсын Зэвсэгт хүчнээс энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн эмэгтэй цэргийн алба хаагчдын 93% нь цэргийн багт, 4% нь цэргийн ажиглагчаар, 3% нь штабын офицероор үүрэг гүйцэтгэсэн бол Нью-Йорк дахь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны газарт 2 эмэгтэй ажилласан байдаг нь бидний бахархал.

Ахлах дэслэгч Ц.БАДАМСҮРЭН

## БАЙЛДАГЧ НАРЫН ДУНД ...



Зэвсэгт хүчний 338 дугаар анги

XVII жарны "Буян үйлдэгч" хэмээх усан Бар жилийн Сар шинийн баярын өдрүүдэд хугацаат цэргийн алба хаагчдын дунд тусгай төлөвлөгөөний дагуу соёл хүмүүжлийн ажлуудыг зохион байгууллаа.

Үндэсний өв уламжлалаа дээдэлбэ уриан дор Сээр хугалах тэмцээнийг зохион байгуулж тэргүүн байрт МБР-ын нэгдүгээр салааны байлдагч Б.Нямсамбуу, дэд байрт Барилга засварын салааны байлдагч О.Эрдэнэхүү нар шалгарч бусдыгаа манлайлав.

Мөн хугацаат цэргийн алба хаагчдын хоорондын харилцаа, хандлага, бие биеэ ойлгож хүндэтгэх, нөхөрсөг уур амьсгал бүрдүүлэх зорилгоор "Намайг уучлаарай, баярлалаа" сэдэвт ярилцлага хийсэн бөгөөд хугацаат цэргийн алба хаагчид нэгэндээ баярлаж явдгаа хэлж, буруу зүйл хийсэн, хоорондоо муудалцаж байсан бол буруугаа хүлээн уучлалт гуйж сэтгэлээ нээсэн үр дүнтэй ярилцлага болов.

Түүнчлэн хугацаат цэргийн алба хаагчдын дунд нэг өдрийг "Талархлын өдөр" болгон зохион байгуулж, тэдэнд бусдад талархсан сэтгэлээ илэрхийлэх боломжийг олголоо. Хугацаат цэргийн алба хаагчид мөр зэрэгцэн алба хааж буй онжав, салааны захирагч, ротын захирагч, ангийн удирдлага, өдөр бүр амт чанартай хоолоор үйлчилдэг тогооч нар гээд ангийн бүхий л бие бүрэлдэхүүнд баярлаж талархаж явдгаа илэрхийлж талархлын захидал бичив.

Дэслэгч Б.ПҮРЭВЛХАМ

## 30 КМ-ИЙН МАРШ ҮЙЛДЭВ

Зэвсэгт хүчний 014 дүгээр анги



2021-2022 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу ахлагч нарын бие бүрэлдэхүүнтэй тактик тусгай бэлтгэлийн цогцолбор 30 км-ийн явган маршийг дайсны хорлон сүйтгэх бүлэгтэй тулгарх, химийн хордолттой газар орныг туулах, холбооны бэлтгэл хичээл гэсэн гурван цэгээр төлөвлөн зохион байгууллаа.



Дэслэгч Р.БИЛЭГ

Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ  
Батлан хамгаалах яам  
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС  
"Соёмбо" сонин  
"Дуулга" студи

\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.  
\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.  
\* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018  
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn  
Утас: 70001029, 3412 (дотуур)